



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 5/39

Улаанбаатар хот

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.3 дахь заалт, Хөдөлмөрийн гэрээний 8.3 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2026 оны 03/5094, 05/5922 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жүгдэрийн Отгонбаатар нь эх, хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг ханган ажиллах чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж, Хөдөлмөрийн гэрээнд заасан зөрчил гаргасан, хөрөнгө орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлэх үүргээ зөрчсөн нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон тул албан тушаалын цалингийн хэмжээг 3 сараар 30 хувиар бууруулсугай.

2. Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны системд сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг оруулахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүний нөөцийн албанд даалгасугай.

3. Ж.Отгонбаатарт Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээсэн үүргийг хангаж, мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж ажиллахыг үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаярт даалгасугай.

САЙД



Э.БАТШУГАР

141260912